



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/78

Алтанбулаг

Г
Г
Мал, амьтны халдварт өвчин гарахаас
урьдчилан сэргийлэх, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих,
сэг зэм устгах, ариутгал халдвартгүйтгэлийн
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 7.4, 7.5, 7.12, Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгавар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 тооот албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/64 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, хүн, мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчин гарах, тархах, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мал, амьтны хүүр, сэг зэм цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдвартгүйтгэлийн хийх ажлыг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга
Гишүүдэд

Ү.Янжиндулам /ЗДТГ-ын дарга/
О.Чинчимэг/МЭТ-ийн дарга, улсын байцаагч/
Б.Баттулга / 1-р багийн Засаг дарга /
Г.Жамбалдорж / 3-р багийн Засаг дарга /
Г.Ган-Эрдэнэ / МЭТ-ийн тархвар зүйч/
Г.Мөнхболд /ХАА-н тасгийн мэргэжилтэн/
Р.Булгаа / МЭҮН-ийн малын эмч /
Л.Гантэмэр /МЭҮН-ийн малын эмч/

2. Ажлын хэсгийн дарга, гишүүдэд Даалгах нь:

2.1. "Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, сарын аяя"-ыг нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 15-наас 05 дугаар сарын 05-ны хооронд олон нийтийг хамруулан чанартай зохион байгуулж, шаардагдах ариутгал халдвартгүйжүүлэлтийн бодис, хүн хүч шатахуун, тээврийн хэрэгслийг гамшигийн нөөц сангаас бүрдүүлж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

2.2. Мал, амьтны хашаа хороо, уст цэг, булаг шанд, гол горхины орчин тойрныг цэвэрлүүлж, өтөг хөрзөнг гадагш гаргаж хураах, мэргэжлийн

байгууллагуудын заавар удирдамжийн дагуу сэг зэм цуглуулах, устгах, орчны цэвэрлэгээ халдвартгүйтгэлийн ажилд идэвхтэй оролцохыг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг болгох.

2.3. Хашаа, хороо, өтөг, бууц, механик цэвэрлэгээ бүрэн хийсний дараа ариутгал халдвартгүйтгэлд бүх малчин, мал бүхий өрх, аж ахуй нэгжийг бүрэн хамруулах.

2.4. Отор нүүдлээр харьяалах нутаг дэвсгэрт ирсэн мал, амьтанд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулах, мал, амьтныг хүлээж авах, шилжүүлэх үед эрүүл мэндийн үзлэгийг хийж, мал эмнэлгийн нэгдсэн цахим системд мэдээллийн бүрэн оруулж, хяналт тавих.

2.5. Төв, суурин газар, улс, аймгийн чанартай зам, малын бэлчээр, тариан талбай, гол горхи, булаг шандын орчимд мал, амьтны хүүр, сэг зэмийг орхиж хаясан эх үүсвэрийг мөрдөн мөшгөж тогтоон буруутай иргэн, хуулийн этгээдэд холбогдо хууль, журмын дагуу хариуцлага тооцдог байдлаар хэвшил болгож ажиллах.

3. Дээрх арга хэмжээг зохион байгуулах явцад хариуцлагагүй хандсан иргэн, хуулийн этгээд, холбогдох албан тушаалтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /О.Чинчимэг/, Засаг даргын тамгын газрын дарга /У.Янжиндулам/ нарт үүрэг болгосугай.

4. Зохион байгуулах ажилд шаардагдах зардлыг Засаг даргын нөөцөөс 50 л шатахун буюу 110,500 /Нэг зуун арван мянга таван зуу/ төгрөгийг гаргахыг төсвийн нягтлан /Э.Цэнд-Аюуш/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

НОТГОНЦОГТ

